



2022 оны 03 сарын 30

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

# АГУУЛГА

---

01

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

Алсын хараа үнэт зүйл  
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ  
Компанийн засаглал  
Хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол  
Тооллогын комиссын тогтоол  
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг  
ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга

02

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2021 оны үйл ажиллагааны товч тайлан  
2022 оны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө

# №3

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Аудитын дүгнэлт  
Санхүүгийн тайлангууд  
Тайлангийн гол үзүүлэлт, харьцаанууд

# №4

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН МАТЕРИАЛ

Хэлэлцэх асуудлууд  
Тогтоолын төслүүд  
Саналын хуудас

# КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ



## АЛСЫН ХАРАА

Дэлхийн жишиг дата төв болж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ дэлхийд экспортолно

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах /үйлчилгээ үзүүлэх/ замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхолыг ханган ажиллах нь компанийн үндсэн зорилго мөн.

## ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС

- Компани төдийгүй эх орныхоо төлөө бие сэтгэл, мэдлэг чадвараа бүрэн дайчлан ажиллаж буй бизнесийн ёс зүйтэй баг, хамт олон.
- Мэдээллийн технологи, өгөгдлийн үнэ цэнийг ойлгож үргэлж хамт байдаг хэрэглэгч, харилцагч, бизнесийн түншүүд.
- Дэлхийд чанараар өрсөлдөх бүтээгдэхүүн, үйлчилгээ.
- Харилцагчийн мэдээллийн аюулгүй байдал.

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

- Ёс суртахуунтай, ил тод, нээлттэй
- Хууль, эрх зүйн хэм хэмжээг дээдэлнэ
- Мэдээллийн аюулгүй байдлыг чандлан сахина
- Байгууллагын зорилгыг өөрийн хүсэл тэмүүлэлтэй уясан мэдлэгтэй чадварлаг ажилчид
- Бусдад хүлээн зөвшөөрөгдсөн чанар
- Биднийг үргэлж дэмждэг хэрэглэгчид

УРИА ҮГ

- Хязгааргүй боломж

“  
**КОМПАНИЙН 10  
ЖИЛИЙН ОЙГ  
ТОХИОЛДУУЛАН БИД ЗАХ  
ЗЭЭЛД ДАХИН ТАНИГДАЖ,  
БАЙР СУУРИА  
БАТАТГАХЫН ТУЛД  
ХЯЗГААРГҮЙ БОЛОМЖ  
УРИАТАЙГААР ИРЭХ  
ЖИЛҮҮДЭД ҮЙЛ  
АЖИЛЛАГААГАА  
ЯВУУЛАХААР НЭГ ШАТ  
ӨГСЛӨӨ.**  
”



Сайн байцгаана уу?

Эрхэм хүндэт хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдээ Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилж байна. 2021 он Монгол Улсад орчин цагийн харилцаа холбооны салбар үүсэж хөгжсөний 100 жил, Айтүүлс компанийн 10 жилийн ой тохиосон онцгой жил байлаа.

Компанийн 10 жилийн ойг тохиолдуулан бид зах зээлд дахин танигдаж, байр сууриа бататгахын тулд Хязгааргүй боломж уриатайгаар ирэх жилүүдэд үйл ажиллагаагаа явуулахаар нэг шат өгслөө. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд бид хэрэглэгчиддээ бодитоос виртуал, виртуалаас клауд технологишуу шилжин үйлчилгээ үзүүлж, үндэсний үйлдвэрлэгч компани гэдгээ улам бүр бататгасаар чадлаа. Мэдээллийн технологийн хурдацтай хөгжил, дэвшилтэй хөл нийлүүлэн алхаж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ тасралтгүй хөгжүүлж, хэрэглэгчээ сурган мэдлэгжүүлж, хэрэглэгч бус бүтээгч, импортлогч биш экспортлогч байхыг зарчим болгон ажиллаж ирлээ.

2021 оны эцсийн байдлаар компанийн нийт хөрөнгө 4,6 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэйгээр тайлант жилийг үдэж байна.

Бид энэ онд Үүлэнхүүг Үндэсний клауд үйлчилгээ болгон өргөжүүлэн хөгжүүлж cloud.mn платформ, маркетплэйсийг зах зээлд нэвтрүүлж мэдээллийн технологийн дэлхийн гегантууд болсон Амазоне клауд, Майкрософт Ажур, Алибаба клауд зэрэг үйлчилгээтэй өрсөлдөн дэлхийн жишиг data төв болж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ дэлхийд экспортлох алсын хараандаа илүү ойртож буйгаа батлан харуулсан жил байлаа. Дэлхийд хүчээ авч буй технологийн зөв, хурдацтай хөгжлөөс хоцрохгүй хөл нийлүүлэн алхахын тулд 2021 онд нийт үйл ажиллагааны 76%-ийг эздийн өмчөөр, 24%-ийг өр төлбөрөөр санхүүжүүлж өнгөрсөн оны ХЭХ-ын тогтоол, шийдвэрийг үндэслэн Үндэсний клауд платформдоо хөрөнгө оруулалт хийсэн нь үр дүнгээ өгч эхэлсэн жил байлаа.

Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах, үйлчилгээ үзүүлэх замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах компанийн үндсэн зорилгодоо хүрэхэд чухал ахиц, дэвшил гаргаж чадлаа хэмээн дүгнэж байна.

Жил дамнасан цар тахлын сөрөг нөлөөний энэ цаг үед бид өнөөдрийн ашиг орлогын төлөө биш, өдрөөс өдөрт үнэ цэн нь нэмэгдэж буй ирээдүйн өгөөжид хөрөнгө оруулсан жил байв.

Түүнчлэн Айтүүлс компани нь Дархан-Уул аймагт дата төвийн зориулалтаар ашиглах боломжтой 4000м<sup>2</sup> газартай 1320м<sup>2</sup> талбайтай үл хөдлөх хөрөнгөтэй болсныг албан ёсоор дуулгахад таатай байна. Мөн Айтүүлс компанийн хувьцаа эзэмшигч Ай Си Ти Групп ХК нь ОУ-ын TIER III төвшний дата төвийн төслийг эхлүүлж, манай компани үйл ажиллагааг нь бүрэн хариуцаж ОУ-д төлөөлөх болсныг баяртайгаар мэдэгдэж байна.

Үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс даруй 48 хувиар өссөн нь Аж үйлдвэрийн IV хувьсгалын үед дата төвийн эрэлт хэрэгцээ өдрөөс өдөрт өсөн нэмэгдэхийг илэрхийлж, баталсан үйл явдал боллоо.

Бидний өнөөдрийн биш маргаашийн үнэ цэнийг харж итгэл хүлээлгэн хөрөнгө оруулсан та бүхэндээ эрүүл энх, саруул сайхан байхыг хүсэн ерөөе.

“  
ЖИЛ ДАМНАСАН ЦАР  
ТАХЛЫН СӨРӨГ НӨЛӨӨНИЙ  
ЭНЭ ЦАГ ҮЕД БИД  
ӨНӨӨДРИЙН АШИГ  
ОРЛОГЫН ТӨЛӨӨ БИШ,  
ӨДРӨӨС ӨДӨРТ ҮНЭ ЦЭН  
НЬ НЭМЭГДЭЖ БУЙ  
ИРЭЭДҮЙН ӨГӨӨЖИД  
ХӨРӨНГӨ ОРУУЛСАН ЖИЛ  
БАЙВ.”

**Б.Тамир**

Гүйцэтгэх захирал





АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 2 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 2/027

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг  
цахим хэлбэрээр зарлан хуралдуулах тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.3 дах хэсэг, 76 дугаар зүйл 76.1.2 дах хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн пурэв гарагт 15:00 цагаас компанийн албан ёсны фэйсбууук <https://www.facebook.com/itools.mn> хаягаар дамжуулан цахим хэлбэрээр зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалтыг [www.uulzalt.mn](http://www.uulzalt.mn) сайтаар хэрэгжүүлсүгэй.
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийг 2022 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалт болон холбогдох мэдээллийг хавсралтаар баталсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг Хавсралт №3-аар баталсугай. /Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа

ириүүлсэн хувьцаа эзэмшигчдийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд уг саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа нь 2022 оны 3 дугаар сарын 30 өдрийн 15 цаг 00 минут хүртэл байна./

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Г.Хатанболдыг томилсугай.

7. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Хурал зохион байгуулах комиссын дарга: Г.Янжинлхам /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

Б.Мөнхцэлмүүн /Захиргаа, хүний нөөцийн ажилтан/

Д.Билэгжаргал /Хэрэглэгчийн үйлчилгээний мэргэжилтэн/

8. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Янжинлхамд даалгасугай.





**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 2 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 21/028

Улаанбаатар хот

**Тооллогын комисс томилох тухай**

Айтүүлс ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдахтай холбогдон Тооллогын комиссыг томилох тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: О.Далайхүү /Системийн ахлах инженер/

Комиссын гишүүд:

- ✓ Д.Жигжид /Борлуулалт, маркетингийн хэлтсийн мэргэжилтэн /
- ✓ А.Мөнхбилэг /Системийн админ/

Тооллогын комисс (О.Далайхүү)-д дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай. Үүнд:

- 1.1. Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх.
- 1.2. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох.
- 1.3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогdon гарах аливаа асуултад тайлбар өгөх.
- 1.4. Санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах.
- 1.5. Саналын хуудсыг тоолж, саналын хуудсыг хүлээн авах бөгөөд санал хураалтын дүнгийн тухай тэмдэглэл хөтлөх.

- 1.6. Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах.
- 1.7. Саналын хуудсыг компанийн архивд хадгалуулахаар шилжүүлэх.





АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 2 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 21/026

Улаанбаатар хот

**Ногдол ашиг хуваарилахгүй тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.1, 46.2, 46.5 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Айтүүлс ХК-ийн үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний тасралтгүй хэвийн байдлыг хангаж, үйл ажиллагааны санхүүжилтэд зарцуулах зорилгоор 2021 оны ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Шийдвэртэй холбоотой мэдээллийг хууль, тогтоомжид заасан хугацаанд холбогдох байгууллага болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Янжинлхамд даалгасугай.

төлөөлөн удирдах  
зөвлөлийн дарга



ГХАТАНБОЛД

Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн  
21/027 тоот тогтоолын 1 хавсралт

## “АЙТҮҮЛС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Айтүүлс” ХК-ийн (цаашид “Компани” гэх)-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Ээлжит хурал” гэх) нь **2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 15 цаг 00 минутад** компанийн албан ёсны фэйсбүүк хуудсаар шууд дамжуулан цахим хэлбэрээр хийгдэх тул хувьцаа эзэмшигчид та <https://www.facebook.com/itools.mn> хаягаар хандаж, хуралдаа оролцоно уу.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц болон санал хураалтыг [www.uulzalt.mn](http://www.uulzalt.mn) веб сайтаар явуулна.  
Ээлжит хурлаар хэллэлцэх асуудал:

Ээлжит хурлаар хэллэлцэх асуудал:

1. 2021 оны ТҮЗ-ийн үйл ажиллагааны тайлан
2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах
3. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТҮЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэллэлцэн батлах
4. Компанийн ногдол ашиг хуваарилах эсэх талаарх ТҮЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
5. ТҮЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулж, сонгох
6. Компанийн ТҮЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны төсөв
7. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь **2022 оны 3 дугаар сарын 10-ны өдөр** (“Бүртгэлийн өдөр”) байна.

Саналын хуудсаар саналаа өгөх хувьцаа эзэмшигчдийн Саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа **2022 оны 03 сарын 30-ны өдрийн 15 цаг 00 минут** байна.

Ээлжит хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын дараах хаягаар холбогдон авна уу.

Ажиллах цагийн хуваарь: Ажлын өдрүүдэд **10:00- 17:00** цагийн хооронд ажиллана.

Компанийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Олимпын гудамж, Реженси ресиденс, 203 тоот

Имэйл: [secretary@itools.mn](mailto:secretary@itools.mn)

Утас: 75755585, 99059722

Айтуулс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн  
21/027 тоот тогтоолын 2 хавсралт

## АЙТҮҮЛС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, ТҮҮНТЭЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2022 оны дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн ажлын өдрүүдийн 10:00-17:00 цагийн хооронд Айтуулс ХК-ийн оффист болон өөрийн харилцаж буй брокер дилерийн компаниуд дээрээ очиж танилцана уу.

Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн хурлын тогтоол
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
4. Айтуулс ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан
5. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт
6. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хурлын ... тоот “Ногдол ашиг хуваарилахгүй тухай” тогтоол
8. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны товч тайлан
9. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийн төсөл
10. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүд
12. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид, тэдгээрийн танилцуулга
13. Саналын хуудас

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

	ХӨТӨЛБӨР	ХАРИУЦАГЧ	ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА
1	Хурлын ирц бүртгэх	Зохион байгуулах комисс Тооллогын комисс	30мин
2	Хурлын ирцийг мэдээллэх	Тооллогын комисс	5мин
3	Хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	Хурлын дарга	10мин
4	Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах	Гүйцэтгэх захирал	10мин
5	Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах	Гүйцэтгэх захирал	10мин
6	Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах	Хурлын дарга	10мин
7	Ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг танилцуулах	ТУЗ	5мин
8	Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд дэвшигчдийг танилцуулах	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	5мин
9	Компанийн ТУЗ-ийн 2022 оны төсвийг танилцуулах	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	5мин
10	Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	Хурлын дарга	10мин
11	Асуулт, хариулт	Хурлын дарга	20мин
12	Санал хураалт	Тооллогын комисс	30мин
13	Хурлын завсарлага, санал тоолох	Зохион байгуулах комисс, Тооллогын комисс	30мин
14	Санал хураалтын дүng танилцуулах	Тооллогын комисс	10мин
15	Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулах	Хурлын дарга	5мин
16	Хурлыг хаах	Хурлын дарга	5мин

Хурлын үргэлжлэх хугацаа: **3 цаг 20 минут**

Жич: Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



### Г.Хатанболд

ТУЗ-ийн дарга

- Санхүүгийн удирдлагын магистр
- Ай Си Ти Групп ХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал



### З.Мягмарсүрэн

ТУЗ-ийн хараат бус гишүүн

- Зах зээл судлаач, эдийн засагч
- Бодь тусгал Аудит ХХК-ийн захирал
- Аудитын хорооны дарга



### Г.Гантуяа

ТУЗ-ийн хараат бус гишүүн

- Бизнесийн удирдлагын докторант
- Бизнесийн удирдлагын магистр
- Номадик контент ХХК-ийн үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал
- Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны дарга, Мэдээллийн аюулгүй байдал, Бизнес хөгжлийн хорооны гишүүн



### Н.Жавхлан

ТУЗ-ийн хараат бус гишүүн

- Төрийн удирдлагын магистр
- Могул Консалтинг сервис ХХК-ийн Гүйцэтгэх захирал
- Бизнес хөгжлийн хорооны дарга, Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, нэр дэвшүүлэх хороо болон Мэдээллийн аюулгүй байдлын хорооны гишүүн



### А.Баттамир

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Техникийн ухааны магистр, докторант
- Мэдээллийн аюулгүй байдлын хорооны дарга
- Бизнес хөгжлийн хорооны гишүүн
- Ай Си Ти групп ХК-ийн үүсгэн байгуулагч, Дэд захирал



### Н.Улаанхүү

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Эдийн засгийн онолч, эдийн засагч
- Цалин урамшууллын хорооны гишүүн



### Б.Эрдэнэжаргал

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Бизнесийн удирдлагын бакалавр
- Дижитал экчэйнж Монголия ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан захирал



### Б.Тамир

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Улс төрийн удирдлагын магистр
- Айтүүлс ХК-ийн Гүйцэтгэх захирал
- Бизнес хөгжлийн хорооны гишүүн



### Б.Амгаланбаатар

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Нягтлан бодогч
- Ай Си Ти групп ХК-ийн Санхүү, удирдлагын газрын захирал



### Г.Янжинлхам

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

- Нийтийн удирдлага магистр, эрх зүйч

Аудитын хороо, Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хорооны гишүүн

# 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

Айтүүлс ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны гол зорилго нь Монгол улсын эдийн засаг, мэдээллийн технологийн салбарт хувь нэмрээ оруулж, чанартай, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээр баялаг бүтээхийн зэрэгцээ, олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд компанийн зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдэд үнэ цэн хүртээх явдал юм. Энэхүү гол зорилгынхоо хүрээнд бид 2021 онд дараах зорилтуудыг тавьж ажилласан. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх
2. Борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх
3. Харилцагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх

Бид энэхүү 3 зорилгын хүрээнд доорх ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр зорилт тавин ажиллаа.

## ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ, НЭВТРҮҮЛЭЛТ

1

Клауд үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэх: Бид 2021 онд борлуулалтын орлого нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Клауд үйлчилгээний платформын хүчин чадлыг өргөтгөх, LMS сургалтын удирдлагын цогц системийн сайжруулалт, хөгжүүлэлтийн ажлыг хийхээр төлөвлөсөн. Гэсэн хэдий жил дамнасан цар тахлын нөлөө болон хил гаалийн хорио цээр зэрэг шалтгааны улмаас 2021 оны эхний хагас жилд импортлон захиалсан дэд бүтцийн өргөтгөл шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн ирэх хугацаа хойшилж тус ажлыг төлөвлөсөн хугацаандаа бүрэн хийж дуусгаагүй байна. 2022 оны эхний хагас жилд дэд бүтцийн ажлыг бүрэн дуусгаж зах зээлд шинэ, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ нээлтийг хийхээр дахин төлөвлөн ажиллаж байна.

Хялбар Веб угсралтын үйлчилгээ: 2021 оны 5 сард хялбар веб угсралт буюу Webdy үйлчилгээний нээлтийг хийж 2021 оны 12 сарын байдлаар нийт 41 идэвхтэй хэрэглэгчтэй болсон байна. Энэхүү үйлчилгээ нь компанийнхаа танилцуулга веб сайтыг хэрэглэгч өөрөө хямд үнээр, чанартай хийх үйлчилгээ бөгөөд Wix.com, Weebly.com зэрэг гадаадын веб сайт угсралтын үйлчилгээтэй ижил төстэй үйлчилгээ юм.

Масс И-мэйлийн үйлчилгээ: Айтүүлс ХК нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн судалсны үндсэн дээр масс и-мэйл буюу олноор и-мэйл илгээх боломж бүхий үйлчилгээг 2021 оны 12 сараас эхлэн зах зээлд нэвтрүүлээд байна.

Энэхүү үйлчилгээ нь хэрэглэгчийн и-мэйл спам төлөвт орох, IP хаяг блоклогдох, и-мэйл явуулах тоо хязгаартай байдаг зэрэг асуудлуудыг цогцоор нь шийдэж чадсан.

Вордпресс хост үйлчилгээ: Вордпресс хост үйлчилгээг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд компанийн хэрэглэгчийн системийн, шинэчлэлийн ажлыг үе шаттайгаар амжилттай хийж бүрэн дуусгасан бөгөөд уг үйлчилгээний сервер, тоног төхөөрөмж хил гаалийн хорио, цээртэй холбоотойгоор 2022 оны 1 дүгээр улирал хүртэл түр хугацаагаар хойшлоод байна.

## ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ, НЭВТРҮҮЛЭЛТ

2

2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтооолоор “Ай Си Ти Групп” ХК-ийн Дархан-Уул аймагт байрлалтай, дэд бүтэц нь бүрэн шийдэгдсэн, ашиглалтад орсон 4000M 2 талбай бүхий 1300M2 обектийг, СЗХ, Дархан-Уул аймгийн газрын алба, Улсын бүртгэлийн газруудын зөвшөөрлийн дагуу өөрийн эзэмшлийн дуусаагүй барилга болон, газраараа сольж гэрчилгээгээ хүлээн авсан. Энэхүү үл хөдлөх болон газрыг компанийн өмч болгосноор олон улсын дата төвийн чанар стандартад нийцсэн дата төвийг ашиглалтад оруулах боломж бүрэн нээгдлээ. Тус төслийг мөн л төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулахаар бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажилласан боловч цар тахлын давагдашгүй хүчин зүйл болон үүнтэй холбоотойгоор өссөн инфляцийн төвшин нэмэгдэж төслийн явц удааширч, ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагаа зогсонг байдалд байгаа зэрэг шалтгааны улмаас хойшиллоо.

## ДЭД БҮТЭЦ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШИНЭЧЛЭЛТ ХИЙХ

3

Дата төвийн найдвартай ажиллагааг хангаж 2021 оны турш 99.991%-н uptime-тай ажиллаж олон улсын TIER 3 стандартыг хангаж ажилласан байна. Дэд бүтцийн найдвартай ажиллагааг хангахын тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

- В1 давхар болон 1 давхрын серверийн өрөөнүүдийн хөргөлтийн төхөөрөмж болон сүлжээний төхөөрөмжийн өргөтгөл хийж дуусгасан
- Үндэсний data төвийн ДАН системтэй хэрэглэгчийн системийг холбох, хэрэглэгчдийн бүртгэлийг сайжруулах ажил хийгдсэн. Ингэснээр хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдал, бүртгэлийн мэдээллийг үнэн зөв бүртгэх зэрэг давуу талыг бий болгосон.
- Үндэсний data төвийн Монголын Интернетийн Харилцан Холболт /МИХХ/ - н холболтыг өөрсдийн Улаанбаатар хотын data төvtэй 40GB холболтоор холбож өргөтгөсөн.

## ХАРИЛЦАГЧ, ХЭРЭГЛЭГЧДИЙГ СУРГАХ, ХАЛАМЖЛАХ

4

2020 онд шинэ харилцагчийн тоо 6%, идэвхтэй харилцагчийн тоо 30% өссөн бол 2021 онд шинэ харилцагчийн тоо 23%, идэвхтэй харилцагчийн тоо 6% өссөн байна. Идэвхтэй харилцагчийн тоо тодорхой төвшнөөр бурсан ба нөлөөлсөн гол хүчин зүйл нь дундын хост үйлчилгээ 31%, Домэйн нэрийн үйлчилгээ 17% нь цуцлагдсан байна. Үйлчилгээ цуцалсан аж ахуй нэгж, байгууллагуудын 90 орчим хувь нь жижиг дунд үйлдвэр эрхлэгчид болон аялал жуулчлал, зочид буудлын үйлчилгээ үзүүлэгчид болох нь судалгаа, тайлангаас харагдаж байна.

Бид хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг тодорхойлох зорилгоор дэмжигчдийн цэвэр оноо болон Хэрэглэгчийн хүчин чармайлтын оноо зэрэг аргуудаар улирал тутам судалгаа хийж, шаардлагатай шийдвэрүүдийг гаргаж ажиллалаа. Үүнд байгууллагын дотоод процессыг сайжруулах, автоматжуулах болон хэрэглэгчдийг сургах, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулсан бөгөөд цаашид 2022 оны зорилтуудад тусган үргэлжлүүлэн ажиллаж байна.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ

5

2021 онд хэдий цар тахлын хүнд нөхцөл байдалд ажилласан ч компанийн үйл ажиллагаа, санхүү байдлын талаарх үнэн зөв мэдээллээр хувьцаа эзэмшигчдийг тогтмол хангаж ажиллахыг зорьсон билээ. 2021 оны улирал тутмын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангуудыг боловсруулж, хуулийн хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлж, компанийн цахим хуудсанд нийтлэж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр цаг тухай бүрт нь мэдээллийг хүргэж ажиллаа.

# 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗОРИЛГО ЗОРИЛТУУД

## ЗОРИЛГО

Айтүүлс ХК-ийн үйл ажиллагааны гол зорилго нь Монгол Улсын эдийн засаг, мэдээллийн технологийн салбарт хувь нэмрээ оруулж, чанартай, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээр баялаг бүтээх зорилготой. 2022 оны үйл ажиллагаанд дараах зорилтуудыг тавьж ажиллахаар төлөвлөж байна.

Тус зорилтуудын хүрээнд 2022 оны ажлын төлөвлөгөөний үр дүнг, жилийн эцсийн байдлаар тодорхойлон тухайн хэмжүүр үзүүлэлтүүдэд бүрэн хүрч ажиллахын тулд багийн гишүүн бүрт зориулан нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан баталлаа. Зорилтуудад хүрч ажилласнаар хэрэглэгчийн сэтгэл ханамж нэмэгдэхийн хэрээр борлуулалтын орлого нэмэгдэх, маркетингийн үйл ажиллагаа болон компанийн дотоод менежмент сайжрах, хүний нөөцөө хөгжүүлэхэд тулгуурлан ажилтнуудын сэтгэл ханамж нэмэгдэнэ гэж үзэж байна.

## ЗОРИЛТУУД

### 1. КОМПАНИЙН ҮНЭ ЦЭНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Энэхүү зорилтын хүрээнд компанийн борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, дата төвүүдийн тасралтгүй ажиллагааг 99.98%-иас дээш төвшинд барьж ажиллах, ашгийн маржинг 10 хувьд хүргэх зэрэг түлхүүр үр дүнд зорин ажиллана. Мөн “Ай дата төв”-д нэмэлт серверийн өрөөг ашиглалтад оруулах, үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээний дэд бүтцийг клауд дэд бүтэцрүү шилжүүлэх, серверүүдийн хүчин чадлын өргөтгөх, “Дундын хост” үйлчилгээний шинэ багцуудыг зах зээлд нэвтрүүлэх, дамжин борлуулах бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэх зэрэг ажлуудыг төлөвлөж байна.

### 2. ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Service Excellence” үйлчилгээг төгөлдөршүүлэх б сарын хугацаатай төслийг, тухайн чиглэлд мэргэшсэн, тэргүүлэгч компанийтай хамтран хэрэгжүүлж өхлээд байна. Төслийн хүрээнд сувгийн оновчлол, үйл ажиллагааны төгөлдөршил, чадавхтай хүний нөөц, технологийн шийдэл, дата анализ зэрэг ажлуудыг төлөвлөөд байна. Айтүүлс ХК нь 2022 онд харилцагч төвтэй үйлчилгээ, харилцагч төвтэй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ур чадвар бүхий ажилтнуудыг бий болгох зорилт тавилаа.

- 1 Компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх
- 2 Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
- 3 Дотоод процессыг сайжруулах
- 4 Ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
- 5 Ажилтнуудын ур чадварыг сайжруулах

### **3. ДОТООД ПРОЦЕССЫГ САЙЖРУУЛАХ**

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Service Excellence” үйлчилгээг төгөлдөршүүлэх 6 сарын хугацаатай төслийг, тухайн чиглэлд мэргэшсэн, тэргүүлэгч компанитай хамтран хэрэгжүүлж өхлээд байна. Төслийн хүрээнд сувгийн оновчлол, үйл ажиллагааны төгөлдөршил, чадавхтай хүний нөөц, технологийн шийдэл, дата анализ зэрэг ажлуудыг төлөвлөөд байна. Айтүүлс ХК нь 2022 онд харилцагч төвтэй үйлчилгээ, харилцагч төвтэй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ур чадвар бүхий ажилтнуудыг бий болгох зорилт тавилаа.

### **4. АЖИЛТНУУДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, УР ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ**

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Service Excellence” үйлчилгээг төгөлдөршүүлэх 6 сарын хугацаатай төслийг, тухайн чиглэлд мэргэшсэн, тэргүүлэгч компанитай хамтран хэрэгжүүлж өхлээд байна. Төслийн хүрээнд сувгийн оновчлол, үйл ажиллагааны төгөлдөршил, чадавхтай хүний нөөц, технологийн шийдэл, дата анализ зэрэг ажлуудыг төлөвлөөд байна. Айтүүлс ХК нь 2022 онд харилцагч төвтэй үйлчилгээ, харилцагч төвтэй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ур чадвар бүхий ажилтнуудыг бий болгох зорилт тавилаа.

# САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ





“АЙТҮҮЛС” ХК-НИЙ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,  
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот  
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;  
Цахим шуудан: altantsersetseg@saudit.mn  
2022.02.17 № СТА/22-06  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**Дүгнэлт**

Бид “Айтүүлс” ХК-ний 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн чухал бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бурдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бид “Айтүүлс” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дун болон мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу үнэн зөв, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт тусгасан.

Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “НБЁЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайландаа орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайландаа өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой.

**ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**  
**“Айтуулс” ХК-ний хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)**

---

**Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага**

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчмитай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

**Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм.

Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайландаа залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бүр тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилттай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог.

**ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**  
**“Айтүүлс” ХК-ний хувьцаа эзэмшигчдэд (ургэлжлэл)**

Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландaa санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоонд суурилна. Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг бид бүхэлд нь үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын ажлын хамрах хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудын талаар харилцсан.

**Бусад зүйлс**

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Компанийн **Хувьцаа эзэмшигчийн захиалсан** аудиттай холбогдуулан “Айтүүлс” ХК-ийн хувьцаа эзэмшигчид зориулан гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

**“СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ” ХХК**  
Мэргэшсэн нягтлан бодогчид



**/Д.АЛТАНЦЭЦЭГ/**  
Захирал, МНБ

Монгол Улс, Улаанбаатар хот  
Огноо: 2022 оны 02-р сарын 17

# 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЛАНС./МЯНГАН ТӨГРӨГӨӨР/

ҮЗҮҮЛЭЛТ	2019	2020	2021
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	74,549	174,871	250,133
Дансны авлага	1,182,859	656,548	518,227
Татвар, НДШ-ийн авлага	-	-	-
Бусад авлага	23,402	1,531	29,664
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	-
Бараа материал	106,532	95,317	114,588
Урьдчилж төлсөн зардал тооцоо	244,705	146	113,046
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-	-
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,632,047</b>	<b>928,413</b>	<b>1,025,658</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	1,471,807	1,465,431	3,497,289
Биет бус хөрөнгө	124,289	91,760	45,443
Биологийн хөрөнгө	-	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	70,446	70,446	70,446
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-	-
Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,008,172	1,008,172	-
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,674,715</b>	<b>2,635,810</b>	<b>3,613,178</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,306,761</b>	<b>3,564,223</b>	<b>4,638,835</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>			
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Дансны өглөг	710,574	41,335	115,807
Цалингийн өглөг	243	551	-
Татварын өр	95,313	59,989	22,141
НДШ-ийн өглөг	-	-	-
Богино хугацаат зээл	-	-	-
Хүүний өглөг	-	-	-
Ногдол ашгийн өглөг	-	-	-
Урьдчилж орсон орлого	301,050	-	-
Нөөц / өр төлбөр /	-	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	-	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ( борлуулах бүлэг хөрөнгө )- нд хамаарах өр төлбөр	-	-	-
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,107,179</b>	<b>101,875</b>	<b>137,948</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Урт хугацаат зээл	-	-	-
Нөөц / өр төлбөр/	-	-	-
Хойшлогдсон татварын өр	-	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-	-
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>997,000</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,107,179</b>	<b>101,875</b>	<b>1,134,948</b>
<b>Эздийн өмч</b>			
Төрийн өмч	-	-	-
Хувийн өмч	1,481,441	1,481,441	1,481,441
Хувьцаат өр төлбөр	-	-	-
Халаасны хувьцаа	-	-	-
Нэмжк төлөгдсөн капитал	763,115	763,115	763,115
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	460,722	460,722	460,722
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-	-
Хуримтлагдсан ашиг	494,304	757,070	798,610
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>3,199,582</b>	<b>3,462,348</b>	<b>3,503,887</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>4,306,761</b>	<b>3,564,223</b>	<b>4,638,835</b>

## 2019, 2020, 2021 ОНУУДЫН ЖИЛИЙН ЭЦСИЙН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН /МЯНГАН ТӨГРӨГӨӨР/

<b>Үзүүлэлт</b>	<b>2019</b>	<b>2020</b>	<b>2021</b>
Борлуулалтын орлого ( цэвэр )	3,086,785	3,234,369	2,546,825
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,385,417	2,282,147	1,574,492
<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>701,367</b>	<b>952,222</b>	<b>972,333</b>
Түрээсийн орлого	19,320	19,545	20,681.82
Хүүгийн орлого	1,048	630	-
Ногдол ашгийн орлого	-	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-	-
Бусад орлого	34,740	5,321	4,000.00
Борлуулалт, маркетингийн зардал	-	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	508,026	648,967	931,434.74
Санхүүгийн зардал	-	-	-
Бусад зардал	18,154	31,198	18,838.71
Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	2,556	2,176	1,506.39
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	(1,911)	(4,302)	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	-	-	-
Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз ( гарз )	-	-	-
Бусад ашиг ( алдагдал )	-	-	-
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>230,940</b>	<b>295,429</b>	<b>48,248</b>
Орлогын татварын зардал	24,909	32,663	6,708.68
<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>206,031</b>	<b>262,766</b>	<b>41,539</b>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (	-	-	-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>206,031</b>	<b>262,766</b>	<b>41,539</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
Бусад олз ( гарз )	-	-	-
<b>Орлогын нийт дүн</b>	<b>206,031</b>	<b>262,766</b>	<b>41,539</b>
Нэгжхувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )	5.98	7.63	1.21

## 2019, 2020, 2021 ОНУУДЫН ЖИЛИЙН ЭЦСИЙН МӨНГӨН УРСГАЛЫН ТАЙЛАН. /МЯНГАН ТӨГРӨГӨӨР/

Үзүүлэлт	2019	2020	2021
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>3,033,215</b>	<b>2,905,335</b>	<b>2,609,282</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	2,654,913	2,895,476	2,599,509
Эрхийн шимтгэл, хураамж төлбөрийн орлого	-	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-	-
Буцаан авсан албан татвар	-	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-	-
Бусад мөнгөн орлого	378,302	9,859	<b>9,773</b>
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,789,167</b>	<b>2,729,022</b>	<b>2,309,421</b>
Ажиллагсдад төлсөн	281,288	269,446	381,183
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	82,553	34,302	107,054
Бараа материал худалдан авахад төлсөн	1,486,394	2,091,929	1,428,449
Ашиглалтын зардалд төлсөн	172,974	2,849	44,965
Тулш, шатахун, тээврийн хэлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,284	-	1,696
Хүүний төлбөрт төлсөн	-	-	105,240
Татварын байгууллагад төлсөн	324,657	152,838	93,058
Даатгалын төлбөрт төлсөн	-	450	-
Бусад мөнгөн зарлага	437,018	177,207	147,776
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>244,048</b>	<b>176,314</b>	<b>299,861</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>158,114</b>	<b>1,149,089</b>	<b>409,645</b>
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-	-
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	-	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө боруулсаны орлого	-	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	157,445	1,148,459	<b>409,645</b>
Хүлээн авсан хүүний орлого	669	630	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>457,741</b>	<b>1,199,506</b>	<b>1,591,418</b>
Үндсэн хөрөнгө олжээмшихэд төлсөн	310,932	-	<b>1,478,455</b>
Биет бус хөрөнгө олжээмшихэд төлсөн	-	-	-
Хөрөнгө оруулалт олжээмшихэд төлсөн	-	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олжээмшихэд төлсөн	-	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	146,809	1,199,506	<b>112,963</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээні</b>	<b>(299,627)</b>	<b>(50,417)</b>	<b>(1,181,774)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>364,295</b>	<b>116,876</b>	<b>1,044,670</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	364,295	114,365	1,043,000
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-	-
Төрөл бүрийн хандив	-	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	2,511	1,670
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>266,372</b>	<b>142,450</b>	<b>87,496</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	266,372	142,265	<b>87,335</b>
Санхүүгийн түрээсийн өглөт төлсөн	-	-	-
Хувьцаа буцаан худалдаж төлсөн	-	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-	185	161
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>97,923</b>	<b>(25,574)</b>	<b>957,174</b>
<b>Валютын ханшийн зөрүү</b>			
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>3,441</b>	-	-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>45,785</b>	<b>100,322</b>	<b>75,261</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>28,764</b>	<b>74,549</b>	<b>174,871</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>74,549</b>	<b>174,871</b>	<b>250,133</b>

# **2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН. /МЯНГАН ТӨГРӨГӨӨР/**

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмжк төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хурийтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,481,441.36	0.	763,114.86	460,721.65	0.	0.	757,070.19	3,462,348.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
Залруулсан үлдэгдэл					0.	0.		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.	0.	0.	0.	0.	41,539.4	262,765.95
Бусад дэлгэрэнгүй орлого	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
Өмчид гарсан өөрчлөлт	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
Зарласан ногдол ашиг	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,481,441.46	0.	763,114.86	460,721.65	0.	0.	798,609.58	3,503,887.46

## **Баланс**

2021 оны эцсийн байдлаар компанийн нийт хөрөнгө 4,6 тэрбум төгрөг, 2020 онд 3,5 тэрбум харин 2019 онд 4,3 тэрбум төгрөг байв. 2021 онд өргөлтийн бус хөрөнгө өссөнтэй холбоотойгоор нийт хөрөнгийн дүн өсөлттэй гарсан байна.

Нийт хөрөнгөд эзлэх өргөлтийн болон өргөлтийн бус хөрөнгийн харьцаа харьцангуй тогтвортой буюу өргөлтийн хөрөнгө нь 2019 онд 38%, 2020 онд 26%, 2021 онд 22% өзэлж байна. Компанийн хөрөнгийн бүтцийг харахад үйл ажиллагааг ихэвчлэн эздийн өмчөөр санхүүжүүлж ирсэн бөгөөд 2021 онд нийт үйл ажиллагааны 76%-ийг эздийн өмчөөр, 24%-ийг өр төлбөрөөр санхүүжүүлж байна.

Энэ нь бид үйл ажиллагаандaa маш бага санхүүгийн хөшүүрэг ашиглаж байгааг илэрхийлэх ба ингэснээр өрсдэлийг бууруулж буй ач холбогдолтой ч хөрөнгийн өгөөжийг бууруулах хандлагатай гэж тооцлоо.

Иймээс компанийн хувьд хамгийн оновчтой хөрөнгийн бүтцийг олж тогтоон зарим үйл ажиллагааг өрийн капиталаар санхүүжүүлэх, капиталын бүтцэд өзэлж буй санхүүгийн хөшүүргийг оптимал түвшинд хүртэл нэмэгдүүлэх нь компанийн үнэ цэнийг өсгөхөд өргөгөр нөлөөлөх боломжтой гэж үзэж байна.

Бид үйл ажиллагааг өрийн капиталаар санхүүжүүлэхдээ компанийн урт болоод богино хугацааны өр төлбөр төлөх чадвар, эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалт хийх төслийн өгөөж, өрсдэл гэх мэт бүх хүчин зүйлсийг сатытар тооцож, хамгийн үр ашигтайгаар зарцуулахад анхаарал хандуулах шаардлагатай юм.

2021 оны өр төлбөр ба эздийн өмчийн хувьд өр төлбөрийн 12% нь богино хугацаат байсан ба урт хугацаат өр төлбөр 88%-ийг өзэлж байна.

Дараах диаграммуудаас компанийн үйл ажиллагааг санхүүжүүлж буй бүрэлдэхүүн хэсгүүдийн хувь хэмжээ хөрхэн өөрчлөгдсөнийг мөн нийт хөрөнгийн бүтэц болоод өр төлбөр эздийн өмчийн хэмжээ болон бүтэц 2019-2021 онуудад хөрхэн өөрчлөгдсөнийг харж болно.

# Компанийн хөрөнгийн бүтэц буюу нийт хөрөнгийн хэдэн хувийг эздийн өмч, өр төлбөрөөр санхүүжиж ирснийг З жилээр харьцуулсан харьцуулалт

## Компанийн хөрөнгийн бүтэц




График №1

## Эздийн өмч өр төлбөр




— Эздийн өмч

— Урт хугацаат өр төлбөр

— Багино хугацаат өр төлбөр

— Өр төлбөр ба эздийн өмч

## Нийт хөрөнгийн бүтэц



— Эргэлтийн бус хөрөнгө

— Бараа материал ба бусад эргэлтийн хөрөнгө

— Дансын ба бусад авлага

— Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

— Нийт хөрөнгө


График №2

График №3

# Орлогын тайлан


2021 оны хувьд нийт борлуулалтын орлого өмнөх оныхоос 21% буурсан, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 31% буурсан үзүүлэлттэй байна. Борлуулалтын орлого буурсан нь програм хангамж хөгжүүлэлтийн үйлчилгээний борлуулалтын орлого буурсантай холбоотой юм. Энэ нь өмнөх онтой харьцуулвал 64%-иар буурсан үзүүлэлт юм. Үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний орлого өмнөх оныхоос 22%-иар өссөн байгаа нь цаашид дата төвийн эрэлт хэрэгцээ тасралтгүй нэмэгдэхийг харуулж байна.

Борлуулалтын орлогод хамгийн өндөр хувь эзэлж буй үйл ажиллагаа нь үндэсний клауд үйлчилгээ (өмнөх оноос 100%-иар), бодит сервер түрээсийн үйлчилгээ (өмнөх оноос 53%-иар), сервер түрээсийн үйлчилгээ (өмнөх оноос 40%-иар) байна. Бүтээгдэхүүн тус бүрээр авч үзвэл, вэб байршуулах үйлчилгээн, VPS, багтаамж нэмэх үйлчилгээний борлуулалтын орлого буурсан, бусад бүтээгдэхүүн үйлчилгээний орлого бүгд өсөлттэй гарсан байна.



Борлуулалтын орлого, ББӨ, цэвэр ашигийн сүүлийн 3 жилийн харьцуулалт

График №5



Борлуулалтын орлого, ББӨ, цэвэр ашгийн сүүлийн 3 жилийн харьцуулалт

## Цэвэр ашгийн маржин

Цэвэр ашгийн маржин нь 2020 онд 8% байсан бол 2021 онд 2% болж буурсан байна. 2020 оныхтой харьцуулахад цэвэр ашгийн маржин буурч, компанийн ББӨ, үйл ажиллагааны зардал нэмэгдсэн нь шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болох "Үндэсний клауд" үйлчилгээг зах зээлд гаргахтай холбоотой өссөн байна.

	2019	2020	2021
Цэвэр ашиг	206,031	262,766	41,539
Борлуулалтын орлого	3,086,785	3,234,369	2,546,825
Цэвэр ашгийн маржин	7%	8%	2%




График №6

## Нийт хөрөнгийн болон эздийн өмчийн өгөөж

	2019	2020	2021
Цэвэр ашиг	206,031	262,766	41,539
Нийт хөрөнгө (дундаж)	3,953,922	3,935,492	4,101,529
ROA	5.21%	6.68%	1.01%

	2019	2020	2021
Цэвэр ашиг	206,031	262,766	41,539
Нийт эздийн өмч (дундаж)	3,096,567	3,330,965	3,483,118
ROE	6.7%	7.9%	1.19%




График №7

## **Нэгж хувьцаанд ногдох ашиг, /алдагдал/ Р/Е харьцаа болон дансны үнэ**

Нэгж хувьцаанд ногдох ашиг/алдагдал/ болон Р/Е харьцаа нь потенциал хөрөнгө оруулагчдын хувьд тухайн компанийн үнэ цэнийг тодорхойлоход маш чухал харьцаа байдаг. Р/Е харьцаа нь компанийн санхүүгийн үзүүлэлтээс гадна хувьцааны үнийг авч үзсэнээрээ хөрөнгө оруулагчдын хүлээлтийг, мөн тухайн хувьцаа хэт үнэлэгдсэн байгаа эсэх талаар мөн таамаг өгч байдаг.

Р/Е харьцааны хувьд тухайн жилүүдийн эцсийн хаалтын ханшаар хувьцааны үнийг тооцон авч үзэхэд доорх байдалтай байна.

<b>Үзүүлэлт</b>	<b>2019</b>	<b>2020</b>	<b>2021</b>
Цэвэр ашиг	206,031	262,766	41,539
Хувьцааны тоо	34,452	34,452	34,452
<b>EPS</b>	<b>5.98</b>	<b>7.63</b>	<b>1.21</b>

<b>Үзүүлэлт</b>	<b>2019</b>	<b>2020</b>	<b>2021</b>
EPS	5.98	7.63	1.21
Хаалтын ханш (12 сарын 31-ээр)	72	83	101
<b>P/E харьцаа</b>	<b>12.1</b>	<b>10.86</b>	<b>83.73</b>

<b>Үзүүлэлт</b>	<b>2019</b>	<b>2020</b>	<b>2021</b>
Нийт хөрөнгө	4,306,671	3,564,223	4,638,835
Өр төлбөр	1,107,179	101,875	1,134,948
<b>Дансны үнэ</b>	<b>92.9</b>	<b>100.5</b>	<b>101.7</b>

Төсөл



**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны \_\_ сарын \_\_

өдөр

Дугаар \_\_

Улаанбаатар хот

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх  
ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт,  
Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон  
Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэндийг  
үндсэн дээр 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлын хурлын шийдвэр, Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хавсралтаар  
баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

Г.ХАТАНБОЛД

Төсөл



## АЙТҮҮЛС ХК-ИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТУХАЙ

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх хэсэгт заасны дагуу Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах дүгнэлтийг гаргаж байна.

Айтүүлс ХК нь 2021 онд 2.5 тэрбумын борлуулалт хийж төлөвлөгөөний биелэлт 66 хувьтай, татварын өмнөх ашиг 48.2 сая төгрөгт хүрч төлөвлөгөөний биелэлт 21 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Энэхүү бууралт нь программ хөгжүүлэлт буюу үндсэн бус үйл ажиллагааг буруулсантай холбоотой юм. Хэдийгээр төлөвлөгөөний нийт биелэлт хангалттай бус байгаа хэдий ч үндсэн үйлчилгээ буюу физик болон клауд сервер түрээсийн үйлчилгээний орлого дунджаар 25- хувиар өссөн нь сайн үзүүлэлт юм. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон компанийн санхүүгийн тайланд “Сэргэлт дөл аудит” ХХК аудит хийж дүгнэлт гаргасан. Хөндлөнгийн аудитын дүгнэлтээр компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон Санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв, шударгаар илэрхийлэгдсэн байна дүгнэсэн байна.

Компанийн үйл ажиллагааны хувьд үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний тасралтгүй хэвийн байдлыг хангаж, Монгол улсын мэдээллийн технологийн салбарт хувь нэмрээ оруулж шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлсэн. Тодруулбал ICS буюу клауд серверийн хүчин чадлыг нэмэгдүүлж, өргөжүүлэхэд нэмэлт хөрөнгө оруулалт хийж, клауд виртуал сервер, клауд диск, хуваалцах платформ зэрэг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж ажиллаа. Мөн түүнчлэн data төвийн тасралтгүй, найдвартай ажиллагаа 99.991%-тай буюу TIERIII стандартын түвшинд ажиллаа.

АЙТҮҮЛС ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төсөл



## АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны \_\_ сарын \_\_

өдөр

Дугаар \_\_

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, 77 дугаар зүйлийн 77.5 дахь заалтыг тус тус удирдлага болгон “Айтүүлс” ХК-ийн 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.

Ердийн гишүүд:

- 1.
- 2.
- 3.
- 4.
- 5.
- 6.

Хараат бус гишүүд:

- 1.
- 2.
- 3.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

Г.ХАТАНБОЛД

Төсөл



## АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны \_\_ сарын \_\_

өдөр

Дугаар \_\_

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүдийн цалин,  
урамшууллын төсвийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.13 дахь заалт, “Айтүүлс”  
ХК-ийн 2022 оны 3 дугаар сарын 30-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын  
шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

- “Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны үйл  
ажиллагааны болон гишүүдийн цалин урамшууллыг **47,107,360** /дөчин долоон сая нэг  
зуун долоон мянга гурван зуун жар/ төгрөгөөр баталсугай.
- Төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

Г.ХАТАНБОЛД



## АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

#	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ЖИЛИЙН ЗАРДАЛ
1	ТУЗ-ийн хурал түүнтэй холбогдох үйл ажиллагааны зардал	1,000,000₮
2	ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал	32,607,360₮
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин, урамшуулал	13,500,000₮
НИЙТ ДҮН		47,107,360₮

Төсөл



**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны \_\_ сарын \_\_

өдөр

Дугаар \_\_

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, “Айтүүлс” ХК-ийн 2022 оны 03 дугаар сарын 30-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

- “Айтүүлс” ХК-ийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.
- Шинэчилсэн дүрмийг улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, бусад холбогдох байгууллагад хүргүүлж баталгаажуулахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Гянжинлхам /УД92111004/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

Г.ХАТАНБОЛД



## АЙТҮҮЛС ХК-ИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

ДҮРМИЙН ХУУЧИН ЗААЛТ	ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН ЗААЛТ
7.1 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 1 (нэг) жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх үргэлжилнэ. /2020 оны 4 сарын 29-ны өдөр/	7.1 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 3 (гурав) жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх үргэлжилнэ. /2022 оны 3 сарын 30-ны өдөр/

## “АЙТҮҮЛС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

- Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: .....
- Регистрийн дугаар:.....
- Эзэмшиж байгаа хувьцааны тоо: ..... төрөл: ...Энгийн....
- Хувьцаа эзэмшигчийн үнэт цаасны дансны дугаар:.....
- Бүртгэсэн УЦК-ийн нэр:.....
- Бүртгэсэн УЦК-ийн ажилтны овог нэр:.....

**Дараах хэлэлцэх асуудлуудад ЕРДИЙН АРГААР санал хураана.**

#	ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ	ЗӨВШӨӨРСӨН	ТАТГАЛЗСАН	ТУДГЭЛЗСЭН	ТАТГАЛЗСАН ТОХИОЛДОЛД ТАНЫ ӨГӨХ САНАЛ
1	Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах				
2	ТУЗ-ийн 2022 оны төсвийг батлах				
3	Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай				

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг (тэмдэг): .....

Огноо: 2022 оны ....-р сарын ....-ны өдөр .... цаг .... минут

Тооллогын комиссын бөглөх хэсэг:

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: **Тийм / Үгүй** (доогуур зурах)

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: .....

## “АЙТҮҮЛС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

- Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: .....
- Регистрийн дугаар: .....
- Эзэмшиж байгаа хувьцааны тоо: ..... төрөл: ...Энгийн....
- Хувьцаа эзэмшигчийн үнэт цаасны дансны дугаар:.....
- Бүртгэсэн УЦК-ийн нэр:.....
- Бүртгэсэн УЦК-ийн ажилтны овог нэр:.....

**Дараах хэлэлцэх асуудалд КУМУЛЯТИВ АРГААР санал хураана.**

#	ТУЗ-Д НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС	НЭР ДЭВШИГЧДЭД ӨГСӨН САНАЛЫН ТОО
1	Ердийн гишүүд	
2		
3		
4		
5		
6		
	Хараат бус гишүүд	
1		
2		
3		
4		

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг (тэмдэг): .....

Огноо: 2022 оны ....-р сарын ....-ны өдөр .... цаг .... минут

**ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ САНАЛ ХУРААЛТЫГ КУМУЛЯТИВ АРГААР ХУРААНА.** Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишиг нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Таны эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхэд нийт 900 саналын эрхтэй /100\*9 гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.

**Тооллогын комиссын бөглөх хэсэг:**

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: **Тийм / Үгүй** (доогуур зурах)

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: .....

## САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй тохиолдолд харилцагч брокерын компаниараа дамжуулан хурлын материалтай танилцан саналын хуудсаа өгөх боломжтой.
2. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. **Ердийн аргаар** өгөх санал хураалтад хэлэлцэх асуудал тус бүр дээр нэгээс олон тэмдэглэгээ хийсэн тохиолдолд санал хүчингүйд тооцогдоно.
4. Гарын үсгээ зураагүй санал хүчингүйд тооцогдоно.
5. Итгэмжлэлээр санал өгч буй итгэмжлэгдсэн төлөөлөгч нь итгэмжлэл дээрх өөрийн баталгаат гарын үсгийг зурснаар санал хүчинтэйд тооцогдоно.
6. Насанд хүрээгүй хувьцаа эзэмшигчийн асран хамгаалагч нь хүүхдийнхээ бус өөрийнхөө гарын үсгийг зурснаар санал хүчинтэйд тооцогдоно.
7. **Кумулятив** аргаар ТҮЗ-д нэр дэвшигчдэд өгсөн нийт саналын тоо кумулятив саналын тооноос зөрсөн тохиолдолд саналын хуудсыг хүчингүйд тооцно.
8. **Гарын үсэггүй санал хүчингүйд тооцогдоно**



itools.mn | 2021 оны тайлан